



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/360

Номгон

Хөгжлийн бэрхшээлтэй, эмчилгээ зайлшгүй шаардлагатай хүүхдүүдийг төсөлд хамруулах ажлын хэсэг байгуулах тухай

“Дэлхийн Зөн Солонгос” олон улсын байгууллагын санхүүжилттэйгээр 2021 оны 06-09 дүгээр сарын хооронд Хөгжлийн бэрхшээлтэй, эмчилгээ зайлшгүй шаардлагатай хүүхдүүдийг төсөлд хамруулах зорилгоор Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 'а' заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хэрэгцээт хүүхдүүдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх” төслийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхжаргал (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Содончимэг (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч)

Ш.Сүнжидмаа (Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн ерөнхий эмч)

Р.Билэгдэмбэрэл (Боловсрол, соёл, урлагийн газрын Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Э.Жүгдэрмаа (Баянхонгор сумын Нийгмийн хамгаалал, хүн ам зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

О.Орхончимэг (Дэлхийн Зөн Баянхонгор ОНХ-2 хөгжлийн хөтөлбөрийн менежер) (зөвшилцсөнөөр)

М.Мөнхзаяа (Дэлхийн Зөн Баянхонгор ОНХ-2 хөгжлийн чиглүүлэгч) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: Б.Алтантуяа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн)


2. Хөгжлийн бэрхшээлтэй, зайлшгүй эмчилгээний шаардлагатай 0-16 хүртлэх насны байнгын асаргаатай хөнгөн хэлбэрийн хүүхдүүдийг сонгон авч эмчилгээ

621010913

2.

үйлчилгээнд хамруулж тайланг 10 дугаар сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Энхбаяр/-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН